

## НЭГ. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Байгууллагын үүсэл

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1974 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 тоот тогтоолоор Хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны шууд харьяа газар, хэлтсүүдийн жижүүр, дуудлага үйлчилгээний авто машиныг нэгтгэн Сангийн Яамнаас баталсан төсвийн дагуу хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны харьяанд хөнгөн тэрэгний авто паркийн зориулалтаар анх байгуулагдаж 1992 онд АДХГЗ-ны 23 дугаар тогтоолоор 46 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэйгээр Улаанбаатар хотын АДХГЗ-ны Авто бааз нэртэй, 1994 оноос Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын авто бааз, 2007 оны 07 дугаар сараас Нийслэлийн төр захиргааны авто бааз нэртэйгээр нийслэлийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар болон өргөжиж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн ажлын алба, нийслэлийн харьяа байгууллагуудад автомашинаар үйлчлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

### 1.2. Байгууллагын бүтэц, орон тоо

Байгууллагын бүтэц, орон тоо нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагддаг бөгөөд хамгийн сүүлд 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын А/995 дугаар захирамжаар тус байгууллагын бүтэц, орон тооны хязгаар шинэчлэгдсэн. Үүнд:

Хэлтэс		Орон тоо
1	Дарга	1
Захиргаа, хүний нөөцийн хэлтэс		9
1	Хэлтсийн дарга	1
2	Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан	1
3	Хүний нөөцийн ажилтан	1
4	Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан	1
5	Үйлчилгээний ажилтан	1
6	Манаач	1
Санхүү, төлөвлөлтийн хэлтэс		1
1	Хэлтсийн дарга	1
2	Эдийн засагч, нягтлан бодогч	1
3	Техникч-нярав	1
Тээвэр, зохицуулалтын хэлтэс		92
1	Хэлтсийн дарга	1
2	Ашиглалтын инженер	1
3	Механик инженер	1
4	Диспетчер-механик	12
5	Үйлчилгээний жолооч	74
6	Механик засварчин	2
7	Сантехникч	1
Хэлтэс 3, нийт албан хаагчийн тоо 105.		Нийт 105

### 1.3. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/995 дугаар захирамжаар Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь дараах чиг үүргийг гүйцэтгэхээр дүрэмд заасан. Үүнд:

1	Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулан, байгууллагуудад автомашинаар үйлчлэх.
2.	Үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслийн болон Төрийн үйлчилгээний соёлд тавигдах шаардлага, стандарт, норм, нормативыг мөрдөх, соёлч боловсон, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх.
3.	Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан балансыг зохих хугацаанд гаргах.
4.	Байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг мэргэжлийн өндөр боловсролтой, дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, жолооч нарын боловсрол, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авах.
5.	Авто үйлчилгээнд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах, жолооч нарын ангилал дээшлүүлэх, сургах мэргэшүүлэх, хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах
6.	Шатахуун, тослох материал, автомашины сэлбэг, дулаан, цахилгаан, усны үнэ нэмэгдэхэд үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар бусад холбогдох газруудтай хамтран боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулан, шийдвэрлүүлж, мөрдөж ажиллах

# ХОЁР. АВТО ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 2.1. Автомашинаар үйлчилгээ үзүүлэх тухай

1. Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/789 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд UB ERP Дотоод удирдлагын системд “Дуудлагын автомашины захиалгын систем”-ийг шинээр нэвтрүүлсэн. Хэрэглэгч байгууллагууддаа тус “Дуудлагын автомашины захиалгын систем”-ийн танилцуулга болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Хангарди ордны Их танхимд зохион байгуулав.



2. Нийслэлийн Засаг даргын 2008 оны 409-р Захирамжаар тогтоогдсон тарифын дагуу нийт 88 тээврийн хэрэгслээр 49 байгууллагын 80 хэрэглэгчдэд болон хөдөө орон нутагт, гадаад дотоодын зочид төлөөлөгчдөд үйлчилсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэглэгч байгууллагуудад нийт 1,034,114 км явж үйлчилсэн байна. 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дуудлагын автомашины захиалга нийт 1227 хүлээн авч үйлчилгээнд гаргасан. Үүнээс UB ERP болон “Дуудлагын автомашин захиалгын систем”-ээр 1136, инженерүүдийн болон диспетчер-механикийн (70135074) утсаар 191, дуудлага ирснээс 100 дуудлага нь захиалагч байгууллагын үйл ажиллагаа хойшлогдсоноос цуцлагдсан

№	ЗАХИАЛГАНЫ ОЙРООД	МЭНГЭ	ДЭЛЭГ	ИМЖ	ЖОДООЧ	УТАС	ТӨЛӨӨ	ЗАХИАЛГА АРСАН	САСВАЛГАХ	БҮРЭЭГЛЭХ ОЙРООД
1	2023.12.26-2023.12.28							Төрийн захиргааны газар	Төрийн захиргааны газар	2023-12-27 08:12
2	2023.12.27-2023.12.27	Өлзийт	05-66954	1120	С.Батбаян	99877302	Бэлэн	Төрийн захиргааны газар	Төрийн захиргааны газар	2023-12-26 09:57
3	2023.12.27-2023.12.27	Анхны	0524руч	900	Ж.Энхтөговч	99087343	Бэлэн	Төрийн захиргааны газар	Төрийн захиргааны газар	2023-12-26 09:55
4	2023.12.26-2023.12.26							Төрийн захиргааны газар	Төрийн захиргааны газар	2023-12-25 17:04
5	2023.12.26-2023.12.28	Саявны 7	0922 39Н	955	З.Баттуул	99905504	Бэлэн	Төрийн захиргааны газар	Төрийн захиргааны газар	2023-12-25 16:05
6	2023.12.27-2023.12.27	Льва	7118АР	950	А.Батбаян	99877309	Бэлэн	Төрийн захиргааны газар	Төрийн захиргааны газар	2023-12-25 15:42
7	2023.12.25-2023.12.25	Сүхрэг	27-709НГ	1120	Х.Ариунд	96078909	Бэлэн	Төрийн захиргааны газар	Төрийн захиргааны газар	2023-12-25 13:36
8	2023.12.26-2023.12.26	Саявны 7	08-17 39Н	955	А.Батбаян	99877309	Бэлэн	Төрийн захиргааны газар	Төрийн захиргааны газар	2023-12-25 13:04

3.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ гэж заасны дагуу 2023 оны 10 дугаар сараас эхлэн тээврийн хэрэгслүүдийн дугаарын өнгийг тод дэвсгэр өнгөөр сольсон.




4.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/1429 дүгээр захирамжаар 2023 оны 12 дугаар сарын 18-наас 2024 оны 01 дүгээр сарын 31-нийг дуустал автомашиныг улсын дугаарын тэгш, сондгойгоор замын хөдөлгөөнд оролцуулахаар шийдвэрлэсний дагуу байгууллагын тээврийн хэрэгслүүд тэгш сондгойгоор замын хөдөлгөөнд оролцуулах зохицуулалтыг хийж ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/1429 дүгээр захирамжаар 2023 оны 12 дугаар сарын 18-наас 2024 оны 01 дүгээр сарын 31-нийг дуустал автомашиныг улсын дугаарын тэгш, сондгойгоор замын хөдөлгөөнд оролцуулахаар шийдвэрлэсний дагуу байгууллагын тээврийн хэрэгслүүд тэгш сондгойгоор замын хөдөлгөөнд оролцуулах зохицуулалтыг хийж ажиллаж байна.





5. Нийслэлийн хэмжээнд дуудлагын автомашин, замын хөдөлгөөний зураглал, байршлын орон зайн мэдээллийг бүрэн хамруулсан үйлдлийн болон хяналтын шинэ дэвшилтэт техник, техник, программ хангамж бүхий нэгдсэн системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын автомашины захиалга, дуудлагын нийтлэг үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд тээврийн хэрэгслүүддээ CP5 төхөөрөмжийг Би Ти Жи Ти ХХК-тай гэрээ байгуулж суурилуулсан. CP5 төхөөрөмж суурилуулснаар автомашины зогсож байгаа болон явж байгаа төлөв, байршил, хотоос орох гарах хөдөлгөөн, ажилтан, албан хаагчийн болон тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, явсан байршлын түүхийг харах зэрэг давуу талтай юм.



6. Газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар Дуудлагын үйлчилгээнд ажиллах үйлчилгээний жолоочийн ажиллах журмыг баталж, дуудлагын автомашинаар үйлчилж буй жолооч нарт танилцуулсан.

## 2.2. Дуудлагын автомашинаар үйлчлэх гэрээ

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/789 дүгээр захирамжийг тус тус үндэслэн "Дуудлагын автомашинаар үйлчлүүлэх гэрээ"-ний үндсэн дээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. 2023 онд Дуудлагын автомашинаар үйлчлүүлэх гэрээг 6 байгууллагатай шинээр байгуулж, 5 байгууллагатай удирдлага солигдсон учир шинэчлэн байгуулав.

1.	Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	23/01	2023.01.19
2.	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	23/05	2023.04.05
3.	Зүүн азийн спорт наадам	23/09	2023.04.14
4.	Улаанбаатар театр ОНӨҮГ	23/10	2023.05.11
5.	Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газар	23/11	2023.09.05
6.	Нийслэлийн Соёл урлагийн газар	23/12	2023.09.04

7.	Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК	23/13	2023.09.05
8.	Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	23/14	2023.09.12
9.	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	23/15	2023.09.21
10.	Нийслэлийн нийтийн тээврийн газар	23/16	2023.10.18
11.	Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл	23/17	2023.09.23

### 2.3. Автомашины засвар үйлчилгээ, парк ашиглалт




- ТҮ-1, Хаврын үйлчилгээгээр 82, өвлийн бэлтгэл ажлын хүрээнд 84 тээврийн хэрэгсэлд тос масло, агаар, салоны болон моторын шүүрийг солилоо. Мөн 90%-тай 100 ш дугуйг тээврийн хэрэгсэлд тавьж өгснөөс гадна 100%-тай 13 ш дугуйны худалдан авалтыг хийж хөдөө ажлын тээврийн хэрэгслүүдэд суурилуулж өглөө. ТҮ-2 техник үйлчилгээг 158 автомашинд графикийн болон зайлшгүй шаардлага үүссэн нөхцөлд засвар үйлчилгээг хийлээ.
- Техникийн үзлэг оношилгоонд 92 тээврийн хэрэгслийг бүрэн хамруулсан.
- Нийт 24 тээврийн хэрэгсэл кузов засварт орсон бөгөөд 3 тээврийн хэрэгслийг механик засварчин Б.Золбоо дриллэн өнгөлгөө хийн засварлалаа.
- 2023 онд засвар үйлчилгээнд нийт 51,4 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн.
- Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хийсний үр дүнд нийт парк ашиглалтын коэффициент 2022 онд 90,2% парк ашиглалт байсан бол 2023 онд 93,3% өссөн үзүүлэлттэй ажиллав.

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай захирамжийг хэрэгжүүлэн 2023 онд тээврийн хэрэгслийг бүрэн даатгалд хамруулан АТӨЯХА Татварт 6,1 сая, авто зам ашигласны төлбөрт 2,1 сая,

агаарын бохирдлын төлбөрт 0,5 сая нийт 9,1 сая төгрөгийг хуулийн хугацаанд холбогдох дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.

2023 онд Засгийн газрын 204 дүгээр тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4 зүйл, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/789 дүгээр захирамжийн дагуу татан төвлөрүүлсэн тээврийн хэрэгслүүдийн 2022 онд 26 тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт шилжүүлж, 8 тээврийн хэрэгслийг балансаас балансад, 37 тээврийн хэрэгслийг мөн Нийслэлийн Өмчийн харилцааны газарт шилжүүлэхээр бичиг баримтыг бэлтгэн явуулсан. Үлдсэн 22 тээврийн хэрэгсэл байгууллагын үндсэн үйл ажиллагаанд буюу үйлчилгээнд явж байна.



2023 онд 48 мэргэшсэн жолоочтой ажилласан бөгөөд нийт жолоочийн 70% мэргэшсэн байна.





Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, бусад төрийн захиргааны болон ОНӨҮГ, байгууллагуудын гадаадын зочдод үйлчилсэн.



*Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хүндэт зочдод үйлчилж буй агшин*





2023 оны байдлаар замын хөдөлгөөний зөрчлийн 3.3 сая төгрөгийн торгуулийг зөрчил гаргасан 51 үйлчилгээний жолооч нараар төлж барагдуулсан.

8/16/23, 11:28 AM Мемориалын баримт

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК тлр: АЮУРЗАНА.О(4521)/473(1010)

**МЕМОРИАЛЫН БАРИМТ № 20230816862800497760**

Добит	GL	110100	Бэлэн	*****90,000.00	MNT	2023.08.16	1.00
Кредит	ЗЦГ-ТОРГУУЛЬ /ТҮР ДАНС/	DP	2694000698	орлого	*****90,000.00	MNT	1.00

Гүйлгээний дүн (үсгээр) **ерэн мянга**

Гүйлгээний утга **0381УБУ ТОРГУУЛЬ ТӨЛӨВ. (3)**

Теллер **Харилцагчийн үйлчилгээний эвхлэлтэн №02** Харилцагч *В. Ариун*


№	Улсын дугаар	Торгууль бичигдсэн огноо	Төлсөн огноо	Дүн	Тайлбар	Бар код
1	0381УБУ	2023-06-05 00:00:00	2023-08-16	20,000.00	Улаанбаатар (аймаг/хот) Сүхбаатар дүүрэг (сум/дүүрэг) 419 ЗГазрын баруун уулзаар (47.92017850, 106.91478820)	3100006230476772
2	0381УБУ	2023-02-27 00:00:00	2023-08-16	20,000.00	Улаанбаатар (аймаг/хот) Баянзүрх дүүрэг (сум/дүүрэг) 107 КТМС-ийн уулзаар (47.926449, 106.94072960)	3100021230014818
3	0381УБУ	2022-06-22 00:00:00	2023-08-16	50,000.00	Улаанбаатар (аймаг/хот) Хан-Уул (сум/дүүрэг) 252 Дарга толгой (47.83954211510720, 106.789844976738)	3100024220037304

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь 2023 онд засвар үйлчилгээний тоног төхөөрөмжийг MNS 4598:2011 стандартын дагуу бүрэн ажилд оруулж засвар үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж байна.




## 2.4. Парк ашиглалт ба тээврийн хэрэгсэл

Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол графикт хугацаанд хийсний үр дүнд техникийн бэлэн байдал бүрэн хангагдаж байна. Мөн Парк ашиглалтын хувьд өнгөрсөн онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. 2022 оны Парк ашиглалтын дундаж үзүүлэлт 90,2% байсан бол 2023 оны парк ашиглалтын дундаж үзүүлэлт 93,3% болж өссөн үзүүлэлттэй байна.



Том оврын Хьюндай Юниверс автобусыг кузов засварт оруулж, өнгө үзэмжийг сайжруулав.





## **Хөдөө орон нутагт дуудлагаар**

Өмнөговь аймгийн Гурван тэс суманд: 2023 онд хөдөө орон нутагт үйлчилгээнд явж байгаа үедээ техникийн эвдрэл үүссэн тээврийн хэрэгслийг механик засварчин Б.Золбоо, үйлчилгээний жолооч Х.Арилдий нар очиж шуурхай



засварлан үйлчилгээг цааш үргэлжлүүлэн хүргэлээ.

2023 онд хөдөө орон нутагт 20 гаруй тээврийн хэрэгсэл, үйлчилгээний жолооч үйлчилгээнд явсан бөгөөд “Ширээ цагаан нуур”, Дундговь аймаг, Архангай, Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Дорноговь зэрэг олон аймгуудаар албан томилолтоор явж үүргээ хариуцлагатай гүйцэтгэж ирсэн.







Ширээ цагаан нуур"-ын хөвөөнд орших гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх

## **ГУРАВ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Санхүү төлөвлөлтийн хэлтэс нь батлагдсан орон тооны хэлтсийн дарга ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч-нягтлан бодогч, техникч-нярвын орон тоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулахад төсвийн тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, өр авлага үүсгэхгүй байх, сахилга батыг чангатгах, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэхэд анхааран байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогыг хяналт тавин удирдлагыг бодит мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Санхүү төлөвлөлтийн хэлтэс нь 2023 оны төсвийн жилийн хүрээнд 4 зорилтын хүрээнд 11 багц ажил төлөвлөн төлөвлөгөөний 98 хувийн биелэлттэй өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх талаар : Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дотоод хэм хэмжээ болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон тайлагнан ажиллаж байна.

Боловсон хүчнийг мэргэшүүлэх: 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Төрийн албаны цалингийн нэгдсэн системд нутгийн захиргааны

байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарыг хамруулах сургалтад ерөнхий нягтлан бодогч Б.Үүрцайх хамрагдав.



Дүрмээр олгосон тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Байгууллагын үндсэн чиг үүрэг, зорилтыг ханган биелүүлэх, төсөв зохиох, санхүүгийн эх үүсвэрийг хуримтлуулах, хуваарилан зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавин өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлж байна. Техникийн улсын үзлэг, оношилгоо, татвар, даатгалд бүрэн хамруулахад 10.2 сая төгрөгийн зардлыг тайлагнан ажиллаж байна.

Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/995 дугаар захирамжийн дагуу байгууллагын бүтэц орон тооны зохион байгуулалтыг нийт 105 ажилтан албан хаагчтай шинэчлэн баталсны дагуу Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн А/01 тоот тушаал, 02 сарын 16-ны өдрийн А/10, 07 сарын 03-ны өдрийн А/25 тоот тушаалын дагуу ажилтан албан хаагчдын цалин хөлсийг сар бүр тогтмол хугацаанд тооцон олгож байна. 2023 оны 02 дугаар сард ажилчдын үндсэн цалинд өөрчлөлт оруулан шинэчилсэн. Үүнтэй холбоотой Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн төсвийн нэмэгдлийг төсвийн тодотголд суулгахаар шийдвэрлүүлсэн. Тайлант хугацаанд цалин хөлсөнд 1,660.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлд 472,4 сая, ХХОАТатварт 123,8 сая төгрөг тус тус зарцуулсан.

Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн шалгалтад хамрагдан шаардлагатай баримт, тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж өгөн зөрчилгүй сайн үнэгээ авч ажилласан. Тайлангийн дүгнэлтийн дагуу төлөвлөгөө боловсруулан гарсан зөрчил дутагдлыг арилгах талаар арга хэмжээ авч биелэлтийг хариу тайлангаар илгээж, Төрийн аудитын цахим системд тайлагнан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА**

ХЭРЭГЛЭГЧ НЭВТРЭХ

02400636

Сануулах

Нэвтрэх

Тусламж

Видео

© 2023 Үндэсний аудитын газрын Мэдээллийн технологийн төв

**ТӨРИЙН АУДИТЫН ТУЛГУУР ЗАРЧМУУД**

- Зарчим 1** **Ёс зүй ба хараат бус байдал**  
Аудитор холбогдох ёс зүйн шаардлагыг хангаж, хараат бус байна.
- Зарчим 2** **Мэргэжлийн шийдэл, хянамаг байдал ба мэргэжлийн үл илтгэх үзэл**  
Аудитор аудитын нөхцөл мэргэжлийн үл илтгэх үзвэр хандуу, мэргэжлийн шийдэлтэй, хянамаг байх замаар мэргэжлийн зөвхөн зөв шийдлийг харгана.
- Зарчим 3** **Чанарын хяналт**  
Аудитор чанарын хяналтын мэргэжлийн стандартын дагуу аудитыг гүйцэтгэнэ.
- Зарчим 4** **Аудитын бөгийн удирдлага ба үр чөлөө**  
Аудитор шаардлагатай үр чөлөөг эзэмшсэн эсвэл олж авах боломжтой байна.
- Зарчим 5** **Аудитын эрсдэл**  
Аудитор аудитын нөхцөл байдалд тохирохгүй тавьсан гэрээг эрсдэлийг уяардана.
- Зарчим 6** **Материаллаг байдал**  
Аудитор аудитын үйл явцын турш материаллаг байдлыг анхаарч үзэнэ.
- Зарчим 7** **Баримтжуулалт**  
Аудитор гүйцэтгэсэн ажил, олж авсан нотолгоо ба гаргасан дүгнэлтийн тухай тодорхой ойлголт өгөх хангалттай дэмжлэггүй аудитын баримт бүрдүүлэнэ.
- Зарчим 8** **Харилцаа холбоо**  
Аудитор аудитын үйл явцын турш үр нөлөөтэй харилцаа холбоог тогтооно.

/АДБОУС - 100 Төрийн Аудитын тулгуур зарчим/

Байгууллагын албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр: Нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллагын дотоод журамд заасны дагуу өндөр настны тэтгэвэрт гарсан 2 ажилтанд 1 удаагийн тэтгэмж болон дурсгалын зүйлс гардуулах үйл ажиллагаа.

2023 онд нийт 4 ажилтан албан хаагчийг сургах, мэргэшүүлэх хөтөлбөрийн хүрээнд техникч-нярав Х.Нандинцэцэг ММНБИНститут, Нийслэлийн засаг даргын тамгын хамруулан 0.4 сая төгрөг зарцуулан ажилласан.

Шинээр мэндэлсэн хүүхдийн эцэгт цалинтай чөлөөг 7 ажилтанд нийт 4.7 сая, эрүүл мэндийн шалтгааны улмаас өөрөө болон үр хүүхэд, гэр бүлийн гишүүд хүндээр өвдсөн 4 ажилтанд 9,1 сая төгрөг, үндэсний үйлдвэрлэлээ дэмжин ажилчдын эрүүл ахуй хортой нөхцөлд ажиллаж буй ажилтан албан хаагчдад эрүүл мэндийг дэмжих зорилгоор Сүү ХК-тай хамтран сүр бүр нормын сүү, тараг авахад 7.3 сая төгрөг, тээврийн хэрэгслүүдийн өнгө үзэмж үйлчлүүлэгчийн тав тухтай байдлыг хангахад зориулан Хаан шаглаа ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан суудлын бүрээс захиалан авахад 7.9 сая төгрөгүүдийг тус тус зарцуулан тайлагнан ажиллаж байна.



Улсын Их баяр наадмаар ажиллах ажилтан тээврийн хэрэгслийн бэлэн байдал, тусгай үүрэг гүйцэтгэж буй ажилтан алба хаагчдын бэлтгэл ажил 2,1 сая төгрөг зарцуулан ажилласан ажилласан.



Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын “Мөнгөн өдөр-2023” цасны баярын арга хэмжээ, байгууллагын нийт ажилтан албан хаагчдын хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Нийслэлийн Засаг захиргааны байрны Иргэдийн танхимд зохион байгуулсан арга хэмжээнд 1.4 сая төгрөг, 5 дугаар сарын 12-ны өдөр Хангарди ордны хурлын их танхимд зохион байгуулсан “Дуудлагын автомашинаар үйлчлэх систем” -ийн танилцуулга хийх ажил, Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын V наадмын шигшээ тэмцээн, 11 дүгээр сард байгууллагын аварга шалгаруулах 6 төрөлт спортын тэмцээн, 12 дугаар сарын 16-ны өдөр бүх ажилчдын тайлангийн хурлын бэлтгэлийг ханган нийт 6.4 сая төгрөгийн зардлыг тус тус зарцуулан ажилласан болно.



Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн ил тод байдал: Шилэн дансны хуулийн дагуу хуулийн хугацаанд буюу сар бүрийн 8-ний дотор, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ний өдөр, улирал бүр нийслэлийн татварын албанд тайлант хугацаандаа тус тус тайлагнан ажиллаж байна. 2023 оны шатахуун нийлүүлэх тендерийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын ажлын хэсэгтэй хамтран үнэлгээний хорооны гишүүнд орж ажиллан амжилттай зохих журмын дагуу зохион байгуулж “Сод Монгол групп” ХХК хамгийн бага үнийн санал ирүүлэн тус тендерт шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.

The screenshot displays the Mongolian Tender System website. At the top, there is a navigation bar with the following menu items: ТӨЛӨВЛӨЛТ, ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ, ГЭРЭЭ, МЭДЭЭ, ХУУЛЬ ЭРХЭЙ, ЦАХИМ ДЭЛГҮҮР, СӨРГАЛТ, АШИГТ МАЛТМАЛ. The main content area features a tender notice for the 2023 winter fuel supply. The notice includes the following information:

- ЭРЭМБЭЛЭЛТ:** 2023-01-27 09:00
- НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТУГ-Д 2023 ОНД ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ**
- Захиалагчийн нэр:** Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
- ХАА-ны журам:** Нээлттэй тендер шалгаруулалтын журам
- Үр дүн гарсан**

On the left side, there is a sidebar with filters for the tender search, including:

- ХАЙЛТ Q**
- Он:** 2022
- Сар:** - Сонгох -
- Төсвийн ерөнхийлөн захирагч:** - Сонгох -
- Захиалагч:**

At the bottom of the page, there is a status message: "0 зэс 0 харагдаж байна (Нийт: 0)".

## ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 4.1. Нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр

Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг үндэслэн амьдрах нөхцөл тааруу, өрхийн орлого багатай айл өрхүүдээр газрын дарга, 3 хэлтсийн дарга нартай хамт нийт 10 айл өрхөөр орж амьдрал, аж ахуйтай нь танилцсан.

2023 онд нийт нийгмийн асуудлыг шийдвэрлэх тухай тушаал гаргаж байгууллагын 5 ажилтан, албан хаагчдад нэн хэрэгцээтэй асуудлыг шийдвэрлэсэн.

### Байгууллагын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-өөс зохион байгуулсан үйл ажиллагаа

1. Байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс санаачлан 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр номын баярын арга хэмжээг нийт ажилтан, албан хаагчид болон тэдний хүүхдүүдийн дунд амжилттай зохион байгуулав.





2. Байгууллагын дэргэдэх Залуучуудын зөвлөлийн 2023 оны ажлын төлөвлөгөөнд байгууллагын албан хаагчдын ар гэрт хүн хүчний тусламж, дэмжлэг хэрэгтэй байгаа айлд очиж туслахаар тусгагдсаны дагуу сар шинийн баярыг тохиолдуулан Зөвлөлийн гишүүд 2023 оны 02 дугаар сарын 11-ний өдөр үйлчилгээний жолооч Л.Нарантуяагийн түлээг дөхүүлж өгсөн. Мөн үйлчилгээний жолооч Д.Мөнхбатын гэрт очиж усыг дөхүүлж өгөх, сар шинийн баярын бууз хийх бэлтгэл ажилд туслалцаа үзүүлэв.



3. Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг угтан Захиргаа хүний нөөцийн хэлтэс болон Залуучуудын зөвлөл хамтран байгууллагын ажилтнуудын эрүүл мэнд, бие бялдрыг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, багийн ажиллагааг идэвхжүүлэх, хамт олны уур амьсгалыг бэхжүүлэх зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Мөнгөн өдөр 2023" арга хэмжээг амжилттай зохион байгуулав.



## Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-өөс зохион байгуулсан үйл ажиллагаа

1. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын 12-18 насны хүүхдүүдэд "Хувь хүний хөгжлийн сургалт"-ыг 2023.03.11-ний өдөр "Энэрэлийн түүчээ" ТББ-ын сэтгэл зүйч, багш А.Отгонбаатар, Э.Биндэръяа нартай хамтран амжилттай зохион байгуулав.



## Албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагаа

1. Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулж буй “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд Байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийн дунд Эссэ бичлэгийн уралдааныг зарласан бөгөөд уралдаанд амжилттай оролцож, шалгарсан 2 хүүхдийн эссээг уншиж танилцуулан Өргөмжлөл, үнэ бүхий зүйл хадгалуулав.





2.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд байгууллагын албан хаагчдын хүүхэд багачуудад зориулан 'Хүүхдийн Ертөнц' арга хэмжээг зохион байгуулав. Арга хэмжээнд хүүхдийн урлагийн тоглолт, үлгэрийн баатрууд, “Аав ээж би” буухиа тэмцээнүүдийг тус тус зохиосон. Мөн байгууллагын ажилтан албан хаагчдын хүүхдүүдээс сурлага, урлаг спортоороо манлайлж амжилт гаргасан хүүхдүүдийг шагнаж урамшуулсан. Алдарт эхийн 2 дугаар одонгоор шагнагдсан эхчүүдийг байгууллагын зүгээс урамшуулав.





4.2023-2024 оны хичээлийн шинэ жилийг тохиолдуулан нэгдүгээр ангид элсэн орж байгаа Хүний нөөцийн ажилтан Б.Эрдэнэхишиг, Диспетчер-механик Т.Болортуяа, Ч.Энхбат, Үйлчилгээний жолооч Г.Өлзийсайхан, А.Батзаяа, Э.Энх-Амар, Г.Гансоронзон, Ц.Нэргүй нарын хүүхдүүдэд баяр хүргэж, хичээлийн хэрэглэл гардуулан өгөв.



#### 4.2.Хурал, хэлэлцүүлэг

1.Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-ын ажилтан, албан хаагчдын бүх нийтийн хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулав.



2.Сангийн яамны “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-ээр цалин хөлс олгох болсонтой холбогдуулан цалин, цаг бүртгэл, хэрэглэгчийн нэмэгдлийн талаарх мэдээллийг байгууллагын дарга Э.Болор-Эрдэнэ албан хаагчдад мэдээлэл хийв.



### Сургалт, семинар

1.2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Стандарт хэмжил зүйн газар, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Хотын стандарт, хяналтын газар хамтран зохион байгуулсан “Эрх зүйн орчны шинэчлэл”, “Төрөөс стандартчилал, хэмжилзүйн талаар баримтлах бодлого”, “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтад Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Б.Солонго, Эдийн засагч-нягтлан бодогч Д.Наранцацрал нар тус тус хамрагдсан болно.





2.Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын Албан хаагчдыг сургах, мэргэжүүлэх хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар 2023-2024 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд Замын хөдөлгөөний дүрмийн тухай сургалтыг Сүхбаатар дүүргийн замын цагдаагийн зохицуулагч дэслэгч, Б.Гантулга, Цахим тоглоомын донтолтын талаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Донтох эмгэгийн сэтгэл засалч н.Буянхишиг нартай хамтран сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулав.





3.Онцгой байдлын ерөнхий газраас иргэдэд гамшгаас өөрийгөө болон бусдын амь насыг авран хамгаалахад сургах зорилгоор жил бүр гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор дадлага сургуулилт явуулдаг. Дуут дохио эхний удаа дуугарахад иргэд “Нуугд-суу-хүлээ” зарчмыг баримтлан өрөө тасалгаандаа аюул багатай байрлалд өөрийгөө хамгаалах арга хэмжээг авч, ширээн доогуур орох, даацын хана, булан тохойд зогссон бол хоёр дахь удаа дуугарахад барилга, объектыг орхин гарахдаа гарын доорх зүйл ашиглан толгойгоо хамгааллаа. Ингэхдээ “Гүйхгүй, эргэж буцахгүй, хашиграхгүй, түлхэлцэхгүй” гэсэн зарчмаар барилгаас гарч, гадаах зай талбайд цугларч, дадлага сургуулилтыг амжилттай зохион байгуулав.



4.2023 оны 09 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд Сангийн яам, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хамтран зохион байгуулсан нярав, эд хариуцагчдад зориулсан сургалтад Техникч-нярав Х.Нандинцэцэг хамрагдав.





5. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан "Стресс менежмент" сургалтад хамрагдав.



6. Байгууллагын албан хаагчдад 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Нийслэлийн Иргэдийн хэрэглээний боловсролын төв НЭМҮТ-н харьяа байгууллагаас "Эрүүл мэнд, зөв хооллолтын дадал"-ын талаар сургалт зохион байгуулав.



7. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.6.2, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 4.2.18 "Дэлхийн хөрсний өдөр болон нийслэлийн хөрс хамгаалах өдрийг тохиолдуулан хөрсний бохирдлоос хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар байгууллагын ажилтан, албан хаагчдын экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн "Экологийн боловсрол" сэдвээр сургалт оров.



8. Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд зааснаар төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг болон ёс зүйн талаар сургалт оров.



9. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Авлигтай тэмцэх газраас хамтран зохион байгуулсан "Авлигтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын оролцоо" зөвлөгөөнд оролцов.





10. Байгууллагын Диспетчер-механикуудад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Тод дэвсгэр бүхий улсын дугаар буюу цэнхэр улсын дугаарын тухай, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/1429 захирамжаар батлагдсан дугаарын хязгаарлалтын тухай, Паркуудын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах талаар сургалт мэдээлэл хийв.




### Бүх нийтийн их цэвэрлэгээ

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн "Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам батлах тухай" 61 дүгээр тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны даргын А/01 баталсан хуваарь, Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Шинэ оныг угтан бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах тухай" 15 дугаар захирамж болон Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын өөрийн санаачилгаар "Бүх нийтийн их цэвэрлэгээ"-г нийт 6 удаа зохион байгуулж байгууллагын орчны 50 метр зам талбай, ногоон байгууламж, явган хүний зам цэвэрлэх, хашаа хайс, хаалга, хаягжилт, цонхоо угаах, засварлах, гэрлийн шон дээрх зарлал, сурталчилгааны хуудсыг хуулж цэвэрлэх, шарилжнаас салгах, цас мөс, хог хаягдлыг цэвэрлэх ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг цаг хугацаанд нь холбогдох газруудад мэдээлж ажиллав.







#### **4.3.Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил**

1.Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын “Албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжих 2023 оны төлөвлөгөөний дагуу байгууллагын ердийн, галлагаатай сууцанд амьдардаг Үйлчилгээний ажилтан Н.Балжинням, Н.Даваажав, Үйлчилгээний жолооч О.Сумъяа, Л.Ганбат, Г.Жаргалсайхан, Сантехникч Ц.Батсайхан, Манаач Ж.Санжаа, Н.Нямаа, Д.Буяннэмэх, нарт сайжруулсан түлшний тусламж үзүүлэв.





## Нийгмийн хариуцлагын хүрээний ажил

2. Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-ын албан хаагчид Үерийн улмаас үүссэн Буянгийн зам, Сэлбэ гол орчмын лаг, шаврыг цэвэрлэв.



## Ахмадуудад чиглэсэн үйл ажиллагаа

1. Сар шинийн баярыг тохиолдуулан алтан баазынхан үе үеийн ахмадуудаа хүндэтгэл үзүүлэв.





2.НҮБ-ын Ерөнхий ассамблей 1992 оноос эхэлж, жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрийг Олон Улсын Ахмадын баяр болгон тэмдэглэхийг дэлхий даяар албан ёсоор тунхагласны дагуу манай улс 1992 оноос эхлэн ахмадын баярыг тэмдэглэсээр 31 дэх жилтэйгээ золгож байна. Байгууллагынхаа үе үеийн түүчээ болсон ахмад ажилтнууддаа Ахмадын баярын мэндийг хүргэж, хүндэтгэл үзүүлэв.



#### 4.4. Өргөдөл, гомдлын талаар

*Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэй холбоотой мэдээлэл*

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамж “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” болон холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөн иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем буюу [www.erp.ulaanbaatar.mn](http://www.erp.ulaanbaatar.mn) цахим хуудсаар болон байгууллага дээрээ иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүүлээн авч ажиллаж байна.

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-т 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт 130 өргөдөл гомдлыг бүртгэн, 130 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 6 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Үүнд:

1. Хүсэлт-130
  - ✓ Байгууллагын албан хаагчид-96
  - ✓ Иргэд-34
2. Гомдол-0 ирсэн байна.
- 3.

#### **Хүснэгт-1 Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа**

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл, гомдол
	5	1	54	130

#### 2023 ОНЫ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд манай байгууллагад ирсэн нийт 130 өргөдөл, гомдлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-д бүртгэсэн байна.

Өнгөрөгч 2022 оны жилийн эцсийн байдлаар 133 өргөдөл, гомдол хүлээн авч хууль зүйн үндэслэлтэй 133 өргөдлийг шийдвэрлэсэн байна. 2022-2023 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг жилийн эцсийн байдлаар дараах графикаар харьцуулсан. (График-1)





2023 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг (диаграмм-2) Захиргаа хүний нөөцийн хэлтэс 106, Санхүү, төлөвлөлтийн хэлтэс 22, тээвэр зохицуулалтын хэлтэст 2, байгууллагын хэмжээнд нийт 130 өргөдөл гомдлоос журмын дагуу хуулийн үндэслэлтэй 130 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна.




(2023 оны жилийн эцсийн байдлаар)

2023 оны жилийн эцсийн байдлаар хандалтаараа тэргүүлж буй асуудал нь иргэнээс ажилд орох хүсэлт 35 (27,13%), нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай 34 (26.36%), ажлаас чөлөөлөгдөх 23 (17.83%), цалин, хөлсний тухай 15 (11.63%), ажилд шилжих, дэвшин ажиллах тухай 10 (7.75%) бусад 12 (9.31%) ирсэн байна. Өргөдөл, гомдлын программд нийт 130 өргөдлийг бүртгэж, 123 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг журмын дагуу 5 хоногт 92 (70.77%), 10 хоногт 20 (15.38%), 15 хоногт 3 (2.31%) 30 хоногт 13 (10.00%), хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 2 (1.54%).

2023 оны байдлаар хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. Өргөдөл, гомдлын индексээр (PCI) 0,87 буюу "B" үнэлгээтэй байна.

**Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:**



Байгууллагын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өдөрт нь хүлээн авч, өргөдөл гомдлын нэгдсэн системд бүртгэж, удирдлагад өдөрт багтаан шилжүүлж, удирдлагын цохолттой ирсэн өргөдөл, гомдлыг тухайн албан хаагч өдөр нь хүлээн авч танилцан, явцын тэмдэглэлийг 10 хоног тутам хийж ажилласан.

2023 оны жилийн эцсийн байдлаар өдөрт нь багтаан аваагүй, шийдвэрлэлтийн тэмдэглэл бичээгүй 113, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол 2 байна. Өргөдөл гомдлын зөрчлийн тайланг өмнөх онтой харьцуулахад 49 нэгжээр өссөн үзүүлэлтэй байна.

**4.5.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар**

Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу байгууллагад хандаж ирсэн 251 , явсан нийт 265 бичиг байна.

Байгууллагын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийтээр дагаж мөрдөх, цаг үеийн шинж чанартай болон байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой захирамжлалын баримт бичгүүд Засгийн газрын 2 тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж 15, Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, албан даалгавар, зөвлөмж нийт 2 тус тус холбогдох заалтыг хэрэгжүүлэн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаж, хяналт тавин ажиллаж байна.



**НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТУГ-ЫН  
БАРИМТ БИЧГИЙН ЭРГЭЛТИЙН ЖАГСААЛТ**


2023 оны 12 дугаар сарын 28

Улаанбаатар хот

№	Баримт бичгийн нэр	2021 оны жилийн эцэс	2022 оны жилийн эцэс
1	Тогтоол	1	2
2	Захирамж	13	15
3	Албан даалгавар, тушаал, зөвлөмж	10	2
4	Даргын А тушаал	50	51
5	Даргын Б тушаал	199	164
6	Ирсэн бичиг: нийт	285	251
	Хариутай бичиг	74	68
	Хариугүй бичиг	211	183
7	Төлөвлөгөө	12	12
8	Тайлан, биелэлт	12	12
9	Өргөдөл, гомдол	133	130
10	Явуулсан бичиг: нийт	250	265
	Тодорхойлолт	6	15
11	Хурлын тэмдэглэл нийт:	63	80
	Захиргааны албан хаагчдын	6	45
	Даргын зөвлөлийн	39	19
	Ур чадварын нэмэгдэл	11	12
	Шуурхай хурал	2	0
	Шагналын	5	4
	Өмч хамгаалах	4	6
12	Гэрээ:	230	230
	Автомашинаар үйлчлэх гэрээ	40	11
	Үр дүнгийн гэрээ	1	1
	Хөдөлмөрийн гэрээ	127	129
	Эд хөрөнгийн гэрээ хариуцлагын	62	70
13	Дүгнэлт	0	60

## Албан хэрэг хөтлөлтийн eDoc.ub.gov.mn

2023 оны жилийн эцсийн байдлаар Захиргаа хүний нөөцийн хэлтэст-135, Санхүү төлөвлөлтийн хэлтэст-33, Тээвэр зохицуулалтын хэлтэст-83 албан бичиг ирж, нийт 251 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин 97,81 хувийн шийдвэрлэлттэй ажиллаж байна.



(2023 оны жилийн эцсийн байдлаар)



(2023 оны жилийн эцсийн байдлаар)

Явуулсан бичгийн шийдвэрлэлт нийт 265 үүнээс


- захиргаа хүний нөөцийн хэлтэсийн 119. Хариутай 4, хариугүй 115 бичиг
- санхүү төлөвлөлтийн хэлтсээс нийт 97. Хариутай 8, хариугүй 91 бичиг
- тээвэр зохицуулалтын хэлтсээс нийт 49. Хариутай 1, хариугүй 48 бичиг



## БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД ИРСЭН ХАРИУТАЙ БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ (2023.01.01-2023.12.28)

Байгууллагын хэмжээнд ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлт 2023 оны 01 дүгээр сарын 01-с 12 дугаар сарын 28-ныг хүртэл нийт 68 хариутай албан бичиг ирсэн байна.

Үүнээс: хугацаандаа шийдвэрлэсэн 62, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 6, шийдвэрлээгүй 0, судалж байгаа 0 албан бичиг байна. Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 91,33%-тай байна.



### Байгууллагын архивын үйл ажиллагааны талаар





Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/15 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Байгууллагын захиргааны албан хаагчдаас 2023 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг авч, 2023 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын дэргэдэх БНШК-н хурлаар хэлэлцэж, батлуулсан.

2023 онд байгууллагын архивт 2022 оны ХХНЖ-ын дагуу захиргаа хүний нөөцийн хэлтэс, тээвэр зохицуулалтын хэлтсээс цаасан суурьтай 126 баримтыг нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авав.

#### 4.6. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон Шилэн дансны тухай хуулийн хүрээнд төрийн үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг “[www.baaz.ub.gov.mn](http://www.baaz.ub.gov.mn)” цахим хуудсанд, байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт, гүйцэтгэл, тайлан мэдээ, Дотоод журам болон бусад дүрэм, журмууд даргын баталсан тушаал, зар, санхүүгийн тайлан мэдээллийг тухай бүрт нь байршуулан ажилласан.





2022 оны байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 48, боловсон хүчний холбогдолтой 209, нийт 257 захирамжлалын баримтыг Нийслэлийн архивын [www.arch.ulaanbaatar.mn](http://www.arch.ulaanbaatar.mn) программд шивж, цахим нөхөн бүрдүүлэлт хийсэн.


2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Нийслэлийн Архивын газрын Төрийн архивын хэлтсийн сан хөмрөгч Г.Ариунцацралд захирамжлалын цахим баримтыг хүлээлгэж өгсөн.

Хуудасны дугаар	Хуудасны өдөр	Хуудасны нэр	Дотоодын дугаар	Хуудасны төрөл	Хуудасны төрөл	Хуудасны төрөл	Хуудасны төрөл	Хуудасны төрөл	Хуудасны төрөл	
010	0105	Нийслэлийн төр захиргааны Агаарын	01	00000	Тухайн	А/05	2	280	280	Хувийн хуудас, хуульчилж буй
010	0105	Нийслэлийн төр захиргааны Агаарын	01	00000	Тухайн	А/07	2	280	280	Удист хөдөлгөөнд шилжүүлж буй
010	0105	Нийслэлийн төр захиргааны Агаарын	01	00000	Тухайн	А/05	4	282	280	Цахим хуудасны баримт хуудас
010	0105	Нийслэлийн төр захиргааны Агаарын	01	00000	Тухайн	А/05	2	280	280	2022 оны жилийн жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хийж буй

Мөн байгууллагын фейсбүүк дэх цахим хуудсыг нээж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг [www.baaz.ub.gov.mn](http://www.baaz.ub.gov.mn), фейсбүүк дэх page хуудас, байгууллагын дотоодын группт нийтлэн ажиллаж байна.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, аюулгүй байдлын үүднээс 3 гарашийн камерын засвар үйлчилгээг АЙ ТИ КЭЙР ХХК-тай 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс гэрээ байгуулсан хамтран ажиллаж байна. 2023 онд нийт 30 дуудлага өгч камерын засвар үйлчилгээ хийлгэсэн.

(2-р паркийн хяналтын камерын сүлжээг бүрэн засварлуулж хамгаалалтын хайрцагтай болгосон)



Тээвэр зохицуулалтын хэлтсийн 2 паркийн хяналтын камер хянадаг процессор эвдэрч шинээр авч холболтыг хийлгэсэн.



Мөн байгууллагын 1, 2-р паркийн камерын хард нь гэмтэж 2023 оны 11 дүгээр сард шинээр авч тавиулсан.





## ТАВ. Бусад

### 5.1. Олон нийтийн үйл ажиллагаа

Монгол Улсад авто тээврийн салбар үүсэж хөгжсөний 98 жилийн ойг тохиолдуулан “Авто тээвэрчдийн баярыг зохион байгуулллаа.



1.Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон хот Иргэний оролцоо" хаврын сод тарих аяны нээлтийн өдрүүдэд Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын хамт олон Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Шинэ нисэх буудлын зам дагуу "Ногоон хэрэм" төслийн талбай "Айдсын ам" гэх газар 2023 оны 05 сарын 15-ны өдөр мод тарьж, 10 дугаар сарын 14-ний өдөр тарьсан моддоо услав.



2."Улаанбаатар марафон" олон улсын гүйлтийн тэмцээнд Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-с нийт 8 албан хаагч 5, 10, 21 километрийн зайд амжилттай оролцов.





1. Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-ын дэргэдэх Залуучуудын зөвлөлийн зохион байгуулсан Бооцоотой нөхөрсөг гар болон хөл бөмбөгийг тэмцээнд зохион байгуулав. 2 төрлийн нийлбэр дүнгээрээ 1-р байранд Баатархүү ахлагчтай "No Rules" баг 2-р байранд Энхбат ахлагчтай "Хүлэгүүд" баг 3-р байранд Батхишиг ахлагчтай "Баазын барсууд" баг



2. Байгууллагын үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан албан хаагчдын дунд 6 төрөлт спортын тэмцээнийг зохион байгуулав.



3. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын байгууллагуудын спортын V дугаар наадмын 3 дугаар бүсийн тэмцээн 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.

